

Олон улсын инженерийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулсан шилдэг сонголт болох Нагаока Технологийн Их Сургууль

Дэлхийн хамгийн аюулгүй орнуудын нэг болох Японы Нагаока Технологийн Их Сургууль нь инновац, олон нийт, олон талт байдлыг дэмждэг дээд зэрэглэлийн байгууламж, байгууллагуудын хүчээр олон улсын оюутнууд дунд улам бүр түгээмэл сонголт болж, дэлхий даяарх төгсөгчдийнхөө гэрэлт ирээдүйг баталгаажуулсаар байна.



«Би ирээдүйг жолоодох манлайлагчдыг төлөвшүүлж, шинэ шилдэг санаачилгыг бий болгодог их сургуулийг бүтээхээр зорьж байна.»

Камадо Шигехару, Нагаокагийн технологийн их сургуулийн ерөнхийлөгч

Технологи, инженерчлэлийн салбарт соёл хорондын хамтын ажиллагаа, инновацыг дэмжихээр Нагаока Технологийн Их Сургууль нь Япон төгсөгчдөдөө гадаадад амжилттай ажиллах боломжийг олгож, боловсролын бат бөх тогтолцоог санал болгодог бол ихэнх олонулсын төгсөгчид нь Япон улсад суурьшиж амжилттайгаар карьераа босгож байгуулж байна. Хүн амын дундаж насжилт нэмэгдэж, 2040 он гэхэд ажиллах хүчний хомсдол

11 сая хүрэх гэж буй Японы хүн амын зүйн асуудалтай холбоотойгоор олон улсын оюутнуудыг Японд ажлын байранд бэлтгэх нь Нагаока технологийн их сургууль гэх мэт дэлхийн жишигт нийцсэн боловсролын байгууллагуудын удирдаж буй сайшаалтай бөгөөд зайлшгүй шаардлагат ажил юм.

Японд дундаж гадаадоо оюутны тоо ердөө 5 хувийг эзэлдэг бол Нагаокагийн Технологийн Их Сургуулийн хувьд аль хэдийн 13 хувьд хүрчээ. Ерөнхийлөгч Камадо Шигехару энэхүү өндөр үзүүлэлтийг тус их сургуулийн дэлхий дахиныг хамарсан их сургууль байгуулах хичээл зүтгэл, гадаадоо оюутнуудад зориулсан Twinning Program зэргийг амжилттай хэрэгжүүлсэнтэй холбон тайлбарлав.

Twinning Program-н хүрээнд оюутнууд Япон хэл дээр суралцахын зэрэгцээ Япон хэлний дэмжлэг үзүүлэх сургалтад хамрагдаж, ОТJ (ажлын байран дээрх) сургалтад хамрагдаж, магистрын зэрэг хамгаалах боломжтой. «Гадаад оюутнуудын 65 хувь нь энэ хөтөлбөрийг дүүргэсний дараа ажлын байртай болж Японы компаниудад бүрэн эрхт инженерээр ажиллаж байгаа юм» гэж ерөнхийлөгч Камадо мөн нэгэн бодит амжилтын түүхээ дурдлаа.

Юуны түрүүнд, тэрээр их сургуулийн профессоруудын хамт бүтээгдэхүүн боловсруулан химийн компанид үр ашиг авчирсан төгсөгчийг дурдав. Японд 19 жил амьдарсан энэ төгсөгч одоо байнгын оршин суух эрхтэйгээр гэр бүлийнхээ хамт амьдарч, хүүхдүүдээ Япон сургуульд сургах бодолтой байгаа аж. Дараагаар нь тэрээр магистрын

чиглэлтэй богино хугацааны гадаадад суралцах хөтөлбөрүүдийг санал болгож, даяаршил, ажилтнуудынхаа мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор гадаадад боловсон хүчнийг сургадаг. Ийм санаачилгуудаар дамжуулан бид кампус доторх даяаршил, олон талт байдлыг сурталчилж байгаа юм. Гадаадад хамтрагч компанид ОТJ чиглэлээр суралцаж бай-



Өндөр нарийвчлалтай SEM бүхий бичил бүтцийн шинжилгээ

хөтөлбөрийг дүүргэж, цахилгаан машин үйлдвэрлэлийн компанид ажилд орсон төгсөгчийг дурдсан. Энэ төгсөгч нь Япон улсын иргэн болж, гадаадад ажилласны дараа эх орондоо ирж, Японтой холбоотой гадаадын компанид ажиллаж байгаа юм.

«Манай олон улсын төгсөгчид Японд амжилттай яваа төдийгүй дэлхий дахинд томоохон хувь нэмэр оруулж, хойч үедээ Японд боловсрол эзэмших боломжийг олгож байна» гэж Ерөнхийлөгч Камадо нэмж хэлэв.

Нагаока их сургуулийн оюутнуудад Нагаока болон гадаадын багш нар хичээл заадаг Twinning Program нь тус их сургууль олон улсын байгууллагуудтай байгуулсан гэрээг хамтын боловсролын хөтөлбөрт хэрхэн ашигладаг болохыг харуулж байгаа бөгөөд «Бид олон улсын их сургуулиудтай эдгээр гэрээний тоог нэмэгдүүлэхийг зорьж байна» гэж ерөнхийлөгч Камадо мөн хэлэв.

«Бид мөн гадаадад ОТJ болон хоёр

сан манай Япон төгсөгчдийн нэг 30 настайдаа тус пүүсийн гадаад дахь салбар компанийн ерөнхийлөгч болсон. Түүний туршлага нь түүнд хэлний мэдлэг, салбартаа мэргэшихэд төдийгүй соёл, зан заншил, сэтгэлгээний арга барилаа сайжруулахад нь тусалж түүний карьерын замд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

«Манай их сургуулийн хувьд хилийн чанад дахь байгууллагуудтай байгуулсан санамж бичиг нь зөвхөн хувийн солилцоо, хамтарсан судалгаа бус, жинхэнэ харилцан ойлголцолд суурилсан хамтын боловсролыг дэмжих зорилготой юм. Энэ нь шинийг санаачилж, дэвшилтэт мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, соёлын янз бүрийн үзэл бодолтой хувь хүнийг хөгжүүлэхэд тусалдаг гэж тэр үзэж байна.»


Мөн тэрээр «Ирээдүйд бид аж үйлдвэрийн өсөлт хурдацтай хөгжих төлөвтэй байгаа улс орон, бүс нутагт инженерүүдийг сургахад хамтрах түншүүдийг хайж байна» хэмээн дурдсан.



Хөрсний туршилт хийх гурван тэнхлэгт аппаратыг бэлтгэсэн



Каратэгийн дасгал (клубийн үйл ажиллагаа)



Өндөр нарийвчлалтай SEM бүхий бичил бүтцийн шинжилгээ
Өндөр нарийвчлалтай SEM бүхий бичил бүтцийн шинжилгээ



Nagaoka University of Technology 50th Anniversary

Developing original knowledge for the future

www.nagaokaut.ac.jp